

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

ХХЕГ-ын Хилийн түүх судлалын секторын

эрхлэгч, доктор (Ph.D), хурандаа Ж.Өвгөнбүргэд

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ХИЛ ОРЧМЫН

БҮСЭД ОРШИН СУУХ ИРГЭД, БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

Аливаа улсын хилийн аюулгүй байдал нь хил орчмын бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилтэй салшгүй холбоотой байдаг билээ. Хил орчмын бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил сайн байх нь хүн амын төвлөрлийг бий болгож, хилийн бүс, зурвасын дагуу үйлдвэр, аж ахуйн байгууллага, өсөн нэмэгдсэнээр хязгаар нутагт суурьших иргэд, үйлдвэр үйлчилгээний харьцангуй биеэ даасан нэгжүүдийг хил орчмын нутаг дэвсгэрт байгуулснаар хилийн тодорхой хэсгүүд байнгын хараа хяналттай, хамгаалалттай, харилцан хамтран ажиллах нөхцөл нь бүрдэнэ.

Монгол Улсад анх 1967 онд Сайд нарын зөвлөлийн 139 дүгээр тогтоол гарч, хилийн цэрэгт туслах бригад байгуулахыг НАХЯ, хилийн аймгуудын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд даалгаж байсан энэ үеэс л ХХТХГ-үүд албан ёсоор улсын хил хамгаалалтад оролцож ирсэн бөгөөд 1993 онд Хилийн тухай хууль, 1996, 2000 онуудад “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ыг Ерөнхийлөгчийн зарлигаар батлуулж, орон нутгийн иргэд, төр захиргааны байгууллагууд хамтран ажиллах эрх зүйн үндэс нээгдсэн юм. Хил хамгаалах байгууллага Монгол Улсын хилийн тухай хуульд зааснаар “Улсын хил хамгаалалттай холбогдсон асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, аймгийн засаг даргатай хамтран холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлэн ажиллаж байгаа субъект билээ. Иймд хил хамгаалах байгууллага нь хилийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхээс гадна хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг ахуйн зориулалтаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж,

байгууллагуудад хил орчмын дэглэмийг сахиулах үүргийг гүйцэтгүүлж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн ХХТХ-ний 14 зөвлөл, сумын 74, багийн 108 хэсэгт 1224 гишүүн улсын хил хамгаалалтад оролцож байна. ХХТХГ-ийн 692 буюу 57% нь хил хамгаалалтад тогтмол, 335 буюу 27% нь улирлын чанартай оролцож, 197 буюу 16% нь зөвхөн бүртгэлтэй байна.

Улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж, ХХТХГ-дийн оролцоог нэмэгдүүлэх, хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд:

- > Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Ногооннуур;
- > Ховд аймгийн Булган;
- > Говь-Алтай аймгийн Алтай;

- > Өмнөговь аймгийн Ноён, Баян-Овоо;
- > Дорноговь аймгийн Хатанбулаг, Замын-Үүд;
- > Сүхбаатар аймгийн Онгон;
- > Дорнод аймгийн Халхгол, Матад, Баян-Уул;
- > Увс аймгийн Сагил;
- > Завхан аймгийн Баянтэс;
- > Хөвсгөл аймгийн Цагаан-Уул;
- > Булган аймгийн Тэшиг;
- > Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
- > Хэнтий аймгийн Дадал сумын удирдлагууд идэвхи санаачлагатай

ажиллаж байна.

Судалгаанаас үзэхэд Монгол Улсын 14 аймаг, 150 багийн нутаг дэвсгэр хил залгаа улстай хиллэж байгаа нь газар нутгийн 25, хүн амын 10,5, нийт мал сүргийн 18 хувь нь энэхүү хязгаар нутгийн бүсэд хамрагдаж байна.

Хилийн аймгуудын ХХТХЗ нь улсын хилийн шугамаас дунджаар 283,5 км, сумын зөвлөл нь 159,8 км, баг 18 км-т тус тус байрлан улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж байна.

1980 онд Монгол Улсын хэмжээнд нэг ХХТХГ-д 5,8 км хилийн хэсэг ногдож байсан бол 2014 онд 6,7км болж буурсан тоон үзүүлэлт гарч байна. 1990 оны үед улсын хил зөрчсөн этгээдүүдийн 2% ХХТХГ-үүд саатуулж байсан бол өнөөдөр 0,1% болж буурсан нь нэг талаас хил залгаа улстай байгуулсан хилийн гэрээгорон нутгийн иргэд хүндэтгэн хилийн зөрчил гаргах үйлдэл нь буурсан, нөгөө талаар хилчдийн албаны үйл ажиллагаа мэргэших чиг хандлага руу орж, хилийн зөрчлийг цаг тухайд илрүүлж байгаа, мөн орон нутгийн засаг захиргаа хил хамгаалах байгууллагатай хамтран идэвхитэй ажиллаж байгаагаар хэмжигдэж байна.

Улсын хэмжээнд нэг ХХТХГ-д дунджаар 6,7 км хилийн хэсэг ногдож, байгаа бөгөөд аймгуудаар авч үзэхэд Баян-Өлгий аймагт 3,1км, Увс аймагт 3,6 км, Хөвсгөл аймагт 7,4 км ногдож нягтрал ихтэй хэсэгт хамрагдаж байхад, Говь-Алтай аймагт 15 км, Хэнтий аймагт 11 км гэсэн тоон үзүүлэлт гарч, хамгийн бага нягтралтай байгаа нь ХХТХГ-ийг хил хамгаалалтад татан оролцуулахад бэрхшээлтэй байгаа нь дээрх аймгуудын нэг туслах хүчинд ногдох хилийн хэсгийн нягтралаас харагдаж байна.

Говь цөлийн бүс: Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь аймгийн 17 сумын нутаг дэвсгэрт ХХТХ-ний 187 гишүүн хил хамгаалалтад оролцож байгаа нь нэг гишүүнд 10,7км;

Тал хээрийн бүс: Сүхбаатар, Дорнод аймгийн 13 сумын нутаг дэвсгэрт ХХТХ-ний 158 гишүүн хил хамгаалалтад оролцож байгаа нь нэг гишүүнд 11,7км;

Уулын бүс: Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай аймгийн 19 сумын нутаг дэвсгэрт ХХТХ-ний 498 гишүүн хил хамгаалалтад оролцож байгаа нь нэг гишүүнд 3.9км;

Ой тайгын бүс: Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгийн 23 сумын нутаг дэвсгэрт ХХТХ-ний 381 гишүүн хил хамгаалалтад оролцож байгаа нь нэг гишүүнд 5, 9 км тус тус оногдож байна.

2014 онд Хил хамгаалах байгууллагаас хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтад иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хилийн аймаг, сумдын засаг дарга нарыг ХХЕГ дээр хүлээн авч, хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, хөдөө орон нутагт ХХТХГ-ийн уулзалт, зөвөлгөөнийг тус бүр 2 удаа зохион байгуулж, нийт 1000 гаруй гишүүдийг хамруулснаар хил хамгаалалтад оролцох иргэдийн идэвхи дээшилж, сүүлийн 5 жилтэй харьцуулахад улсын хэмжээнд хилийн зөрчил 51,2%, илрүүлэлт 26,3% буурч, шийдвэрлэлт 15,3% өссөн байгаа нь харагдаж байна.

2014 онд аймаг, сумдын ХХТХЗ-өөс улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж, хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нийт 111,1 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд хилийн аймаг, сумдын удирдлагаас говь цөлийн бүсийн хилийн отряд, заставуудад 53,1 сая, тал хээрийн бүсэд 24 сая, уулын бүсэд 2 сая, ой тайгын бүсэд 31,8 сая төгрөгийн тусламжийг тус тус үзүүлсэн байна.

Хилийн аюулгүй байдлыг хангахад орон нутгийн иргэд, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Хил хамгаалах байгууллагаас ихээхэн чармайлт гарган ажиллаж байгаа бөгөөд цаашид хил орчмын нутаг дэвсгэрт орон нутгийн иргэдийг суурьшуулах, ялангуяа говь цөлийн бүс нутагт бэлчээр, усны хомсдлоос мал аж ахуйг хөгжүүлэх боломж хязгаарагдмал байгаа нь хууль, эрх зүйн орчин, нийгмийн хамгаалалын салбарыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага гарч байгааг цаг үе харуулж байна.

Нөгөө талаар орон нутгийн удирдлага, засаг захиргааны нэгж хилийн аюулгүй байдлыг хангахад ямар эрх, үүрэгтэй оролцохоо төдийлэн сайн мэдэхгүй байгаа нь ихээхэн саад болж байна. Энэ нь:

Төрийн захиргааны албан хаагч, иргэдийн хил хамгаалалтын талаархи хууль эрхийн мэдлэг сул, санаачлагагүй;

Төрийн албан хаагч, орон нутгийн иргэд хил хамгаалалтад оролцох талаархи үүргээ сайн ойлгож ухамсарлаагүй;

Улсын хил хамгаалалт, хилийн цагийн байдалд орон нутгийн удирдлага, иргэд тодорхой ач холбогдол өгдөггүй, мэдээлэл, харилцан ажиллагаа хангалтгүй байгаа зэрэг олон зүйлийг дурдаж болно.

Улсын хил хамгаалалтад ХХТХГ, орон нутгийн засаг захиргааны нэгжийг оновчтой татан оролцуулах гол зорилго нь хилийн болон хил орчмын дэглэмийн

биелэлтийг сахиулах. түүнд хяналт тавих явдал юм. Иймд хил хамгаалалтыг зохион байгуулж буй отряд. заставын дарга нар иргэд. байгууллагатай ажил хэргийн холбоог тогтоож. “Хот айл”, “Малчны нөхөрлөл”-ийг хариуцсан хилийн хэсэгтээ байгуулах шаардлагатай байна.

Гэтэл өнөөдөр эд материалын ойр зуурын дэмжлэг үзүүлэх, баяр ёслол, аж ахуйн чанартай зарим ажлыг хамтран гүйцэтгэх байдлаар хязгаарлагдаж, хил хамгаалалтад иргэд. байгууллагыг үр дүнтэй татан оролцуулах, тэднийг газар орон дээр нь зохион байгуулж, байнгын ажиллагаатай байлгах хэмжээнд хүрч чадахгүй байна. Энэ нь хил хамгаалалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага урган гарч байгаатай холбоотой гэж үзэж байна. Эдгээрийг хэрэгжүүлэхэд дараах ажлыг хийх нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байна. Үүнд:

1. Төрийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэдэд хилийн талаархи хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг судлуулах, тэдэнд сургалт, семинар зохион байгуулж. Удирдлагын акедемид жил бүр аймаг, сумын засаг дарга нарын сургалт явуулдаг цаг үетэй уялдуулж Хил хамгаалах байгууллагаас нэгдсэн сургалт, семинарыг зохион байгуулах;

2. Хилийн аймаг, сумын төсөвт улсын хил хамгаалалт, туслах хүчний гишүүний үйл ажиллагаанд шаардагдах тодорхой хөрөнгийг тусгуулах, үйл ажиллагааг дэмжсэн сан бий болгох;

3. “Улсын хил хамгаалалтад идэвхи зүтгэлтэй оролцож, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг удаа дараа илрүүлсэн ХХТХГ-ийг хилийн отряд, аймгийн цэргийн штабын даргын саналыг үндэслэн аймгийн засаг дарга 5 хүртэлх хүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх урамшууллыг жилд нэг удаа улсын хил хамгаалалтад төсөвлөгдсөн зардлаас олгоно” гэсэн заалтыг Хилийн тухай хуульд тусгах;

4. “Хилийн отрядын дарга, сумын их эмчийн дүгнэлтийг үндэслэн ХХТХГ-ийг жилд нэг удаа аймаг, хот руу явах замын нэг талын зардлыг автомашинаар тооцон хил хамгаалалтад төсөвлөгдсөн зардлаас олгоно” гэсэн заалтыг мөн Хилийн тухай хуульд нэмж оруулах;

5. Хил хамгаалах байгууллагаас орон нутгийн удирдлагатай хамтран хил орчмын иргэдэд хилийн бүс, зурваст газар эзэмшүүлэх замаар тогтвор суурьшилтай оршин суух нөхцлийг бүрдүүлж, тэдгээр нь эзэмшсэн газрын хэмжээгээр хил хамгаалалтад тодорхой үүрэгтэй оролцож, үүнийхээ үр дүнгээр хариуцлага хүлээж, бас урамшуулал хүртдэг тийм тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх;

6. Аймаг, сумдын захиргаанд хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлтийг хариуцсан орон тооны мэргэжилтэнг бий болгох.

Ингэснээр орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирч, хилийн аюулгүй байдлыг хангахад тодорхой үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

7. Мөн орон нутгийн засаг захиргааны удирдлага, цэргийн штабтай хамтран хилийн бүс, зурваст оршин суух цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн судалгааг гарган гэрээ байгуулан тэднийг хавар, намрын улиралд цөөн хүчээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулах үед ар тал, хангалтын чиг үүрэгтэй ажилд туслуулах.

Ингэснээр хүн, хүч хэмнэх, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмэрээ оруулна гэж үзэж байна.

8. ХХТХГ-ийг тухайн хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүрээ, хариуцсан хилийн хэсэг, түүний замнал, байрлалыг хилийн отрядын шуурхай удирдлагын мэдээллийн санд оруулж, харилцан ажиллагаа, үүрэг гүйцэтгэх журмыг тодотгон өгч, удирдлагаар хангах. Энэ нь хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

9. Хилийн аймгийн засаг даргатай ХХЕГ-ын дарга, сумдын засаг даргатай хилийн отрядын дарга жил бүр хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг байгуулан үр дүнг жилийн эцэст тооцож, тэргүүний ХХТХЗ, гишүүдийг тодорлуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлыг зохион байгуулах;

10. Гурван жилд нэг удаа бүсүүдийн төвд ХХТХГ-ийн зөвөлгөөнийг зохион байгуулж, харилцан туршлага солилцох, үзэсгэлэн семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хамтран ажиллах журмаа тодорхойлон үр дүнгээ дүгнэдэг журмыг хэвшүүлэх зэрэг болно.

Мөн улсын хилээ бүх нийтээр хамгаалах нэгдсэн системд шилжих асуудлыг төрийн оролцоотойгоор зохицуулах зайлшгүй шаардлагатай байна. Улсын хил, хил орчмын дэглэмийн биелэлтийг төрийн оролцоотойгоор, төрийн захиргааны байгууллагууд орон нутгийн засаг захиргаа, иргэдийн идэвхтэй дэмжлэг, нягт харилцан ажиллагаатайгаар зохион байгуулснаар хил хамгаалалтын нэгдсэн систем бүрдэж, хилийн аюулгүй байдал хангагдаж, хил хамгаалалтын чанар, үр дүн дээшлэнэ гэж үзэж байна.